

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 11 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 5 удаа хуралдаж 23 асуудал хэлэлцэж, 13 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 16 өргөдөл бичгээр хүлээн авч, 11 өргөдлийг шийдвэрлэж, 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 17 өргөдөл бичгээр хүлээн авч, 14 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2 өргөдөл хүлээн авч 2 өргөдлийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэлт 77.1 хувьтай байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 47 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 41, биечлэн 6 иргэн санал, гомдол ирүүлснээс талархал 1, гомдол 21, санал хүсэлт 23, шүүмжлэл 2 тус тус бүртгэж, холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэсэн.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу тайлант сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна. Засгийн газрын 1111 төвд ирсэн 23 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, 22 санал хүсэлтийн хариуг илгээж, шийдвэрлэлт 95.6 хувьтай байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 11 дүгээр сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн хийгдэж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, цалин хөлс, тогтмол зардал, орон нутгийн хөгжлийн сан, мал эмнэлгийн зардлуудыг хянаж санхүүжүүлээ.

2017 оны улсын нэгдсэн төсөвт өөрчлөлт орж, Улсын Их Хурлаар батлагдсантай холбогдуулан орон нутгийн 2017 оны төсвийн тодотгол, 2016 оны төсвийн гүйцэтгэлийн санал боловсруулж, Засаг даргын зөвлөл, ИТХТ-ийн хурлаар тус тус хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар батлууллаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/578 дугаар захирамжаар орон нутгийн төсвийн 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, уг ажлын хэсэг төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаанд Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-д өргөн барив. Мөн ажлын хэсэг орон нутгийн төсвийн 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг сум, байгууллагуудаас авч нэгтгэн өр, авлага ихтэй сум, байгууллагуудад оны эцэст өргүй гарах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолын 14 заалт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, авилга, ил тод байдлын төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд гаргаж холбогдох хэлтэст хүргүүлэв.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Мянгад сумын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтаар ажиллаж байна.

Татварын хэлтсийн хяналт шалгалтанд ХХК-2, ББН-2, хоршоо-1, салбар-1-ийг тус тус хамруулаад байна. Татвар төлөгч бүрт гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 52.9 сая төгрөгийн зөрчилд 4.4 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 1.3 сая төгрөгийн торгууль, 1.1 сая төгрөгийн алданги, нийт 6.9 сая мянган төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдуулав.

Үл хөдлөх эд хөрөнгийн тооллого хийх, түгээмэл тархацтай ашигт малтмалын татварын ногдуулалт, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, татвар төлөгч иргэний мэдээллийн нэгдсэн сан бий болгох, далд эдийн засагтай тэмцэх, татварын ногдуулалт болон төлөлтийг сайжруулах, орон нутгийн төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Алтай, Үенч, Цэцэг, Жаргалант сумдын нутаг дэвсгэр дэх үл хөдлөх хөрөнгийн тооллого, татвар төлөгч иргэнийг бүртгэлжүүлэх, хөрөнгийн тооллогын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дугаар сарын 10-ны өдрүүдэд хийж, тооллогын хугацаанд нийт 47 төрлийн үйл ажиллагаагаар 512 үл хөдлөх хөрөнгө тоологдож, тооллогод хамрагдсан хөрөнгүүдийн 334 үл хөдлөх хөрөнгө нь 0.2-2.1 сая төгрөгийн үнэлгээтэй ба 2.0-17.5 мянган төгрөгийн татварын ногдуулалт төлдөг байхад бусад 178 хөрөнгөнд татварын тооцоо хийв.

Ажиллах хүчний судалгааг Жаргалант сумын Бугат, Мөст сумын Улаантолгой, Булган сумын Байтаг багуудад, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Бугат, Мөст сумын Цэцэг гол, Булган сумын Байтаг багуудын нийт 62 өрхөд хийж, судалгааны материалаа хянан шалгаж, баталгаажуулж байна. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжил-статистик” сэдэвт үндэсний чуулганд аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан 13 хүн оролцож мэдээлэл солилцов.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хэлтсийн хурлыг 4 удаа хийж, 10 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 3 иргэний анхан шатны бичиг баримт боловсруулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Шинээр албан тушаалд томилогдсон 2 албан тушаалтны ХАСХОМ-ийг хүлээн авч цахимд шивж баталгаажууллаа.

Архивын тасаг нь 18 иргэнд лавлагаа, магадлагаа олгож, тайлант сард 4 хөмрөгийн 89 хадгаламжийн нэгж, 1986-1990, 1992-1995, 1969-1991, 1981-2003 оны 1618 хуудас баримтыг данс, бүртгэлийн хамт цахим хэлбэрт шилжүүллээ.

Цагдаагийн газар: Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй "Залуучуудын хөгжил 2013-2017" төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт холбогдох алба хаагчид оролцож, хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд эерэг хандлагыг төрүүлэхэд юунд анхаарах, тулгарч байгаа асуудлыг нь төрийн болон төрийн бус байгууллага хэрхэн хамтран шийдвэрлэх, цаашид анхаарах асуудлын талаар харилцан санал бодлоо солилцов.

Зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 төрлийн анносыг шинээр хийлгүүлж Бичигтийн хөтөлд байрлуулав.

Ховд Их сургууль, Политехник коллежийн “Оюутны холбоо”-той байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 35 оюутанд чиглэл зааварчилгаа өгч, оройн эргүүлийн алба хаагчдын хамтаар “Оюутан эргүүл”-ээр 7 хоног ажиллуулж, цахим сүлжээгээр олон нийтэд сурталчиллаа. Архаг архичин, орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд архаг архичин 25, тэнэмэл 18 иргэдийн судалгааг гаргаж, эдгээр хүмүүст яриа таниулга хийж, санал бодлыг нь сонсов.

Аймгийн Прокурорын газар, Дарви сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Хууль сурталчлах өдөрлөг”-өөр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Эрүүгийн хууль”-иудаар сургалт зохион байгуулж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч, цахим сүлжээгээр олон нийтэд хүргэу ажиллав.

Мөн бүх шатны төрийн албан хаагчид нийт 468 хүнд шинээр батлагдсан хууль тогтоомжуудаар сургалт хийж, залилан, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сүүлийн өдрүүдэд аймгийн хэмжээнд гарч буй хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч, хүүхэд багачууддаа тавих хараа хяналтаа сайжруулахад анхаарах талаар зөвлөгөө өглөө.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж байгууллагын харуул хамгаалалтын хяналтыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, орон байр, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн санамж, зөвлөмжийг байрны орц, хүн олноор цугларсан үзвэр үйлчилгээний газар, захууд, байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбарт байрлуулан олон нийтэд сурталчилж, байгууллагуудад байрлуулсан камер нь стандартын шаардлага хангасан эсэхэд үзлэг шалгалт хийж, зааварчилга, мэдэгдэл хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд 2017 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар 24 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: хулгайлах 7, үүнээс малын хулгай 2, иргэдийн өмчийн хулгай 5, хүчиндэх 1, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3, бусдыг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 2, хөрөнгө завших 1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3, хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох 3, бусад гэмт хэрэг 2 тус тус бүртгэгдэж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 281 гомдол мэдээлэл хүлээн авсны 30 буюу 10.6 хувийг гэмт хэргийн талаарх, 251 буюу 89.3 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд зөрчил гаргасан 115 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан 32 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, 39 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 233 хүнийг 30.540.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажиллав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Хорих ангийн харуул хамгаалалтыг журмын дагуу зохион байгуулан ажиллаж

байгаа бөгөөд ангийн даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн шуурхай бүлгийн алба хаагчдыг томилуулан ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу тус ангийн тасаг нэгжүүд шөнийн болон өдрийн цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийг шалган гарч болзошгүй гэмт хэрэг, учирлаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Тус газраас алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр анхаарч 64,5 тонн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр алба хаагчдад олгов. Мөн ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж, 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнд сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж байгаа бөгөөд Монгол улсын Засгийн газрын 01 дүгээр “Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” албан даалгаврын хүрээнд төлөвлөгөө гарган ангийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ховд аймаг дахь Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээний дагуу хуваарьт өдрүүдэд тус ангиас 2 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллуулав.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүхийн шинжилгээний албанд хандаж 36 албан бичиг /үүнээс хугацаатай 21 албан бичгийн хариуг заасан хугацаанд өгч/, 52 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 35 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрт ч Ховд” аяны хүрээнд төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохиогдсон Буухиа тэмцээнд хамт олноороо амжилттай оролцов.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 8 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 40 хүнд, бэлгийн холбогдолтой 6, хавтаст хэргийн материалаар 1, химийн 9, биологийн 9, криминалистикийн 9 шинжилгээг тус тус хийж, нийт 82 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд 3 удаа явж үүрэгт ажлаа гүйцэтгэв. ДНК-ийн санг 8, сумны хонгио 46, хошуу 46 ширхэгээр тус тус баяжуулсан.

Гэмт хэргийн газрын үзлэгт 33 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 19, гутлын мөр 18, тээврийн хэрэгслийн мөр 11 бусад ул мөр болон эд мөрийн баримт 38-ыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 85-г авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийгдэв. Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 499 хийснээс шинжилгээний 24, хэргийн газрын үзлэгийн 337, цогцосын үзлэг задлан шинжилгээний 63, бусад 73-г хийж, цагдаагийн байгууллагад хүргүүлсэн.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох, бүтцийн шинжилгээ, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулж, төлбөрт үйлчилгээний орлогод 4,953,000 төгрөг төвлөрүүлэв.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард нийт 2911 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 2141, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 552 ба шилжин ирсэн иргэд 102, шилжин явсан иргэд 27 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 492, гадаад паспорт олголт болон сунгалт 233, иргэний үнэмлэх шинээр олгосон 203, сунгалт 248, дахин олгосон 94, иргэний бүртгэлийн лавлагаа 421 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 390 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 620, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 143 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Иргэдээс 7 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 5 өргөдөлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсрол, соёл, спортын чиглэлээр: Аймгийн боловсрол, соёл, урлагийн газар хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх, төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 25 сургууль, төрийн өмчийн 31, хувийн өмчийн 13 цэцэрлэг, соёлын 16 төв, театр, музейн 87 нэгжийг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын баруун бүсийн сургалт болж тус сургалтанд Увс, Баян-Өлгий, Завхан, Баянхонгор аймгийн бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүд оролцож туршлага солилцов.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд Алтай, Үенч, Булган сумдын нийт 51 хүүхдийг хамруулсан ба үүнээс 32 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 7 хүүхдийг асаргааны тэтгэмжид хамруулав. Боловсролд тэгш хамруулан сургахад багшийн ажиллагаа шаардлагатай цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхдэд, ерөнхий боловсролын сургуулийн 8 сурагчид, албан бус боловсролд хамруулах шаардлагатай 4 сурагчид тус комиссын шийдвэрээр боловсролд илгээх хуудас олгож, багшид нь 5 хувийн нэмэгдэл цалин олгуулахаар шийдвэрлэн багш, сургалтын менежерт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгөв.

“Чадварлаг Ховдчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэгч багш нарын арга зүй, бүтээлч туршлагаудыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хот хөдөөгийн сургуулиудын физик боловсролын орчин, сургалтын үйл ажиллагааны онцлог, ололттой талуудыг харьцуулах, хамтран ажиллах, үйл ажиллагааг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалтанд Ерөнхий боловсролын сургуулийн 28 багшийг хамруулж чадавхжууллаа.

Дэлхий нийтийн тогтвортой хөгжил, Монгол улсын ногоон хөгжлийг дэмжигч боловсролын үзэл санаанд суурилсан олон улсын эко сургууль хөтөлбөрийн

“Сургуулийн орчин” сэдэвт сургалт, ОХУ-ын Буриадын Улаан-үд хотноо “орос хэлний сургалтын тулгамдаж буй асуудлууд” сургалтанд Ховд аймгаас 2 хүн, Хөгжмийн багш нарын хамтын ажиллагааг сайжруулах, бие биенээсээ суралцах боломж бий болгох, хамтарч уран бүтээл туурвих, хөгжим тоглох чадварыг нэмэгдүүлэх, сургалт, түүх, нийгмийн ухааны багш нарын чадавхижуулах сургалт, Хөгжимт драмын театр, Музей, Нийтийн номын сангийн ажилтнууд нийт 80 хүнд “Соёлын ажилтны ёс зүйн” сургалт, Жаргалант сумын цэцэрлэгийн эрхлэгчдэд “Япон улсын сургуулийн өмнөх боловсролын туршлага” сэдвээр сургалт уулзалт зохион байгууллаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг сайжруулах, шалгалтын үр дүнд тулгуурлан сургалтын чанар, нөхцөл байдлаа тодорхойлох, үнэлэх, харьцуулсан судалгаа хийх, түүнчлэн даалгаварын гүйцэтгэл, хариултын шинжилгээг сургууль, анги бүлэг бүрээр гаргаж цаашдын ажлаа тодорхойлох зорилгоор төвийн 7 сургуулийн сурагчдын дунд хими, физикийн хичээллийн “Их сорил”-ын шалгалтыг зохион байгуулав.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж буй “Суралцагчдын ухаалаг хэрэглээ ба сургалтын үйл ажиллагаа” сэдэвт илтгэлийн уралдааны II дахь шатны шалгаруулалтын бүтээлийг хүлээн авч, Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтний зөвлөл танилцаж, 10 багшийн илтгэлийг шалгаруулав.

БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд мэдээллийн технологийн дэд бүтэц, зохион байгуулалт, сумдад суурилагдсан тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, холбох аргачлалын талаар чиглэл өгөх сургалтанд холбогдох албан тушаалтнуудыг хамруулав.

БСУГ-ын ажлын хэсэг Мөнххайрхан, Цэцэг сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

6-11 дүгээр ангийн 45 төрлийн 21541ш сурах бичгийг 10 дугаар ангийн 13 төрлийн шинэ сурах бичгийг хүлээн авч сургуулиудад хувиарлан хүргүүлж, сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Аймгийн хэмжээнд зориулалтын гал тогоотой 10 сургууль, зориулалтын бус гал тогоотой 4, гал тогоогүй 10 сургууль байгаа мэдээг БСШУСЯ-д хүргүүлээ.

Соёл, Спортын чиглэлээр: Монголын Үндэсний Түүхийн музейгээс санаачлан Музейн үүсэл хөгжлийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэнгээр 21 аймгийн Музейгээр дамжуулан олон нийтэд дэлгэн үзүүлэх боломж олгож, тус аймагт 2017 оны 11 дүгээр сарын 08-15-ний өдрүүдэд нээлтээ хийж 60 гаруй хүнд үзүүлж сонирхуулав.

”Хууль журам миний амьдралд” аяны хүрээнд аймгийн Цагдаагийн газраас “Гэр бүлийн хүчирхийллийн тухай”, “Зөрчлийн тухай”, “Залилангийн гэмт хэргийн тухай” хуулиудаар, аймгийн БСУГ-аас соёлын ажилтнуудын дунд “Соёлын ажилтны ёс зүйн” сэдвээр тус тус сургалт зохион байгуулж, тус сургалтанд ажилтнууд хамрагдаж хууль эрх зүйн боловсролоо дээшлүүлэв. Сургалтаар ёс зүй гэж юу болох, соёлын ажилтны ёс зүй ямар байх, үйлчлүүлэгчтэй хэрхэн харьцах зэрэг ёс зүйн хэм хэмжээний талаар онол болон практикт тулгуурлан харилцан ярилцсан үр дүнтэй сургалт боллоо.

Аймгийн Нийтийн номын сан нь тайлант сард 358 уншигчдад карт нээж, 6221 ирцэд 6837 ном, сонин хэвлэл олгож иргэдэд үйлчлэн, ээлжит номын тооллого

хийгдэв. Өсвөрийн яруу найрагчдыг дэмжих, тодруулах, авьяас чадварыг нээн хөгжүүлэх "Ган үзэг" яруу найргийн уламжлалт наадмыг Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран амжилттай зохион байгууллаа. Наадамд аймгийн ЕБС-ийн сурагчид болон хөдөөгийн 12 сумаас нийт 120 залуу найрагч оролцов.

Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 111 жилийн ойд зориулсан "Шувуун саарал" богино өгүүллэг, уран уншлагын наадмыг 21 дэхь жилдээ зохион байгуулж, "шилдэгийн шилдэг гранпри шагналтан"-ыг тодруулан цахим хуудсанд оролцогчдын бүтээлийг байршуулж, алдаршуулав.

Мөн "Ихэр заяа" өдөрлөгийг жил бүр зохион байгуулж хэвшсэн ба энэ удаагийн арга хэмжээнд Жаргалант сумын ЕБС-иудын авьяаслаг, хөдөлмөрч ихэрүүд оролцлоо. "Ухаан далай номоос эхтэй -2 " аяны хүрээнд "Иргэдийн өдөр"-г зохион байгуулж, Америк мэдээллийн төв, гэрээр ном олгох тасаг, эрдэм шинжилгээ-чөлөөт уншлагын танхимууд өөр өөрсдийн онцлогийг харуулсан ном, товхимолоор үзэсгэлэн гаргаж, байгууллагын үйл ажиллагаагаа сурталчлав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн тэгш оролцоог хангах, номтой нөхөрлүүлэх хамтын ажиллагааг сайжруулах үүднээс тус төвийн хүүхдүүдтэй 7 хоног бүр уулзан тэдний саналыг сонсож, үлгэрийн цаг, чөлөөт уншлага, танин мэдэхүйн чиглэлээр хамтран ажиллаж байна.

Аймгийн Хөгжимт драмын театр нь 2017 оны өвөл цагийн уран бүтээлийн 80 дахь жилийн нээлтийн үйл ажиллагаагаар ахмад уран бүтээлчидтэй хамтран 8 уран бүтээлийг сэргээн туурвих ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон ажиллаж, 6 уран бүтээлийг үзэгч түмэндээ өргөн барилаа.

Аймгийн Биеийн тамир спортын газар 2017 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу спортын 10 төрлөөр 550 гаруй тамирчин, сурагчид бэлтгэл сургуулилтанд хамрагдаж, бэлтгэл 1-5 дахь өдрүүдэд өглөө, өдөр 2 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд бүс, улсын чанартай тэмцээнүүдэд бэлтгэгдэж байна.

Баруун бүсийн чөлөөт бөхийн аварга шалгаруулах тэмцээнд Биеийн тамир спортын газрын тамирчид оролцож 2 алт, 2 хүрэл медаль хүртсэн амжилт гаргав.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тайлант сард Эрүүл мэндийн салбарын ажлын үнэлгээний дүнг нэгтгэх, тусламж үйлчилгээнд гарсан ололт амжилтыг үнэлэн тайланд тусгах, хөтөлбөр төслүүдийн үр дүн, үр ашгийг нэгтгэн хэлэлцэхэд онцгой анхаарч ажиллаа. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор хүчний байгууллагуудын 68 ажилтан, албан хаагчдад Эрүүл зохистой хооллолт, архи, тамхины хор хөнөөл болон ходоод, элэгний өвчлөл дасгал хөдөлгөөний ач холбогдол, Томуу томуу төст өвчин болон Зүрх судасны эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн мэдээлэл өгч, сумдын Эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлыг зарласан болзол, аяны дагуу шалгарууллаа. ЭМС-ын 122 дугаар тушаалын дагуу товлолын вакцинд хамрагдах хүүхдүүдийн вакцин, биобэлдмэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зохих хэмд хадгалж, вакцины хүйтэн хэлхээний горимд тогтмол хяналт хийн, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өглөө.

Эрүүл мэндийн үзлэгийг 285443 хүнд хийж үүний 58636 буюу 20.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. Явуулын хэлбэрээр Жаргалант, Дуут, Чандмань, Үенч, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан, Цэцэг, Булган, Дөргөн, Мөст, Мянгад сумдын эрүүл мэндийн төвүүд 2344 иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулав. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээ хийх эрхийг аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Ач заяа, Мөнхцохилохуй эмнэлгүүд хийх эрх авч иргэдийн өөрсдийн саналаар 3 багц үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны элэгний В,С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд 18320 иргэн хамрагдахаас 10810 хүн хамрагдаж 59 хувьтай байна.

“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд улаанбурхан улаанууд, гахай хавдрын товлолын дархлаажуулалтыг 99,6 хувьтай гүйцэтгэж, товлолын дархлаажуулалтаас хоцорсон 6 хүүхдийг улаанбурхан, гахай хавдар, улаанууд өвчнөөс сэргийлэх вакцинаар нөхөн дархлаажуулсан ба амьсгалын замаар дамжих халдварт өвчний тохиолдол 135 буюу өмнөх оныхоос 691 тохиолдлоор буурч, улаан бурхны өвчлөл бүртгэгдээгүй байна.

Эх баригч, багийн эмч, холбогдох бусад мэргэжилтнүүдийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн нэн шаардлагатай асуудлаар чадавхжуулах сургалтыг зохион байгуулж нийт 256 мэргэжилтэн хамрагдаж, тулгамдаад байгаа хүүхдийн мэс заслын тоног төхөөрөмжийг олгоход 6 сая төгрөгийн дэмжлэгийг “Эх хүүхдийн ээлтэй тусламж, үйлчилгээ” хөтөлбөрөөс санхүүжүүлэн олгож, 1829 эхийг эсэн мэнд амаржуулан 1845 нярайг эсэн мэнд эх барьж, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 41 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төрсөн эхийн тоо 33, 5 хүртэлх хүүхдийн эндэгдэл 1 тохиолдлоор тус тус буурсан байна.

2017 онд эрүүл мэндийн 7 байгууллагын магадлан итгэмжлэлд орох хүсэлтийг хүлээн авч Эрүүл мэндийн яаманд хүргүүлсний дагуу Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн баг ирж магадлан итгэмжлэлийн хяналт шалгалтыг хийж эрхийг сунгах арга хэмжээг шийдвэрлэв.

2017-2018 оны өвөлжилт хүндэрч болзошгүйтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдлын цаг үеийн мэдээлэл, судалгааг 16 сум, 6 өрхөөр гарган нэгтгэж Эрүүл мэндийн яаманд хүргүүлэв.

Аймгийн Өрхийн эрүүл мэндийн төв, эмийн сангуудад аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран 5 өрхийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэх эрх бүхий 11 эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн 2017 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл лабораторийн урвалж оношлуур нийлүүлэх тендерийн жил дуусаж байгаатай холбогдуулан 2018 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур худалдан авах тендер зарлахаар бэлтгэл ажил хийгдэж Булган

сумын нэгдсэн эмнэлэг, Мөст сумын сум дундын эмнэлэг, 14 сумдын эрүүл мэндийн төвүүдийн тендерийн захиалгыг авч нэгтгэн тендер зарлахад бэлэн болоод байна.

Санхүү төсвийн ил тод байдлын талаар анхаарч Эрүүл мэндийн салбарын 25 байгууллагуудын 2017 оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн болон өр авлагын мэдээг байгууллага бүрээр хүлээн авч нэгтгэн, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн ба салбарын хэмжээгээр 11705,1 сая төгрөгийн эх үүсвэрээр 11472,1 сая төгрөгийн зардалд зарцуулж 233,1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Салбарын тусгай зориулалтын шилжүүлгийн 2018 оны төсөв батлагдаж ирснийг сумдын ЭМТ-үүдэд журмын дагуу хуваарилж аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн аймгийн ИТХ-д өргөн барив.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр: Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд улсын төсвөөс нийт 1.837.0 сая төгрөгийн санхүүжилт авснаас алдарт эхийн одонд 1.230.0 сая төгрөг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 101.0 сая төгрөг, ахмадын “Насны хишиг” тэтгэмжинд 506.0 сая төгрөгийн тус тус санхүүжилтийг зарцуулав.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа, хяналтын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээллийн сан, мэдээлэл цуглуулалт, өрхийн оноо бодсоны дараах үр дүнг харьцуулах хяналтын тооллогыг Жаргалант, Мөнххайрхан, Дөргөн сумдад хийж гүйцэтгэв.

Өрхийн сангийн мэдээллийн судалгаанд хамрагдаагүй 1350 хүүхдүүд болон 250-иад өрхийг дахин үнэлгээнд хамруулан мэдээллийн баазад шивлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон ахмад настангуудад орчин үеийн тоног төхөөрөмжөөр сэргээн засах үйлчилгээг үзүүллээ.

Идэвхитэй ажил хайгч 148 иргэнийг бүртгэж, 352 иргэний мэдээллийг шинэчлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүлсэн. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд 1740 ажилгүй иргэд бүртгэлтэй байгаа ба шинээр бий болсон 544 ажлын байрыг бүртгэв. Ажил олгогч аж ахуй нэгж байгууллага иргэдээс 1363 ажлын байрны захиалга авч, бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 1274, үүнээс байнгын 786, улирлын 170, түр 318 ажлын байранд зуучлагдсан байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд нийт 1132 иргэд, үүнээс бүлгийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 989, ганцаарчилсан зөвлөгөөнд 163 иргэнийг хамруулав. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 8 аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжиж 1,850,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэв. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5 иргэн хамрагдаж, 10,0 сая төгрөг, мэргэжил олгох оёдол, эсгүүрийн сургалтанд 20 иргэн, Уламжлалт уран хатгамлын сургалтанд 18 иргэнд нийт 704,0 мянган төгрөг, хувиараа хөдөлмөр эрхэлж буй 18 ахмадад 27,0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр тус тус олголоо.

Цагаан уул ахмадын сувилалд Манхан, Жаргалант, Буянт сумын нийт 23 ахмад амрааж 1,744,000 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллав.

Асруулагчдад стандартын дагуу өдөрт 4 удаа 15 нэр төрлийн хоол хүнсээр илчлэгийг нь тооцон үйлчилж, тэднийг халуун усанд оруулж, хэвтрийн асруулагчдад өдөр бүр тогтмол мэргэжлийн асаргаа үйлчилгээ үзүүлж, асруулагчдын даралт хянан эрүүл мэндийн зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж ажиллав.

БОЭТөвд 3740,0 сая, Булган сумын эмнэлэгт 436,2 сая, Мөст сум дундын эмнэлэгт 52,0 сая, хувийн хэвшлийн 5 эмнэлэгт нийт 259,6 сая, эмийн үнийн хөнгөлөлтөнд 499,9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Тайлант сард өндөр насны тэтгэвэрийн 12562591,1 мянган төгрөгийг 7530 хүнд, тахир дутуугийн тэтгэвэрт 1743 хүнд 2103912.2 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 824 хүнд 1065685.2 мянган төгрөг, цэргийн тэтгэвэрт 214 хүнд 614700.7 мянган төгрөг, үйлдвэрийн ослын тэтгэвэрт 38 хүнд 70992,9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 1176 даатгуулагчид 1243865.4 сая төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 750 даатгуулагчид 801116.1 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 1631 даатгуулагчид 370456.2 сая төгрөг, 295 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 295,000,000 төгрөгийг олгож зарцуулав.

ЭХМКомиссын ээлжит хурал 4 удаа хуралдаж, 247 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааны асуудлыг хэлэлцэж 160 иргэний актыг сунгаж, 38 иргэний актыг цуцалж ажилласан ба 43 иргэний хугацааны актыг шинээр тогтоов. 11 дүгээр сарын мэдээллийн баазад шилжиж явсан 2, нас барсан 3, 3332 хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус бүртгэлтэй байна

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, оролцооны чиглэлээр: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон баривчлах арга хэмжээ авч Цагдаагийн газарт саатуулагдсан 18 иргэнд 3 удаагийн сургалт хийж зөвлөгөө өгөв. Гэр бүлийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд хүүхдүүдийн өөрсдийн дуу хоолойг сонсож, оролцоог нь нэмэгдүүлэх, дэвшүүлсэн санал, санаачлагыг насанд хүрэгчид болон шийдвэр гаргагчдад хүргэх зорилготой “Хүчирхийллийн эсрэг нүдээ нээ” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, сурагчдын дуу хоолойг сонсох, хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний оролцоог дэмжих, өрсөлдөх чадварыг бий болгосноор бие биенээсээ суралцах, үзэл бодлоо хуваалцах боломжийг бүрдүүлэх зорилготой “хүүхдийн хөдөлмөрт үгүй гэж хэлье” сэдэвт чөлөөт тэмцээнийг ЕБС-ийн сурагчдын дунд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагийн газар хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн тусламжийн үйлчилгээний 108 утас болон аман яриагаар эрсдэлт нөхцөлд байгаа үл хайхрах байдал, хүчирхийлэлд өртсөн, 6 тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хамтарсан багт зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучууд хөгжлийн төвийн дэргэдэх клуб, зөвлөлийн 50 гаруй залуучууд нэгдэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг зөв тодорхойлох, тэдний оролцоог нь нэмэгдүүлэх, санал, хүсэлтийг шийдвэр гаргагчдад хүргэх зорилготой “Хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн эрхийн хэрэгжилт ба нийгмийн дэмжлэг” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 15 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг Бүгд найрамдах улсаа тунхаглан анхдугаар үндсэн хуулиа баталсан түүхэн өдөр буюу 2017 оны 11 дүгээр сарын 26-ний өдөр зохион байгуулсан ба уг арга хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон аймгийн удирдлагууд оролцов.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлөөс “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, мэдээлэл солилцох, түүний илрүүлэлтийг сайжруулах нь” сэдэвт бүсийн зөвлөгөөнийг 2017 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулж, тус зөвлөгөөнд баруун бүсийн аймгуудын хууль хяналтын байгууллагуудын төлөөлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд оролцов. Сургалт зөвлөгөөнөөр хүрээлэн байгаа орчны гэмт хэрэг зөрчил, хууль бус агнуур худалдахаас урьдчилан сэргийлэх, түүний илрүүлэлт шийдвэрлэлт болон холбогдох хууль эрхзүй, төрөөс баримталж буй бодлого, байгууллагуудын хамтын ажиллагаа, гэмт хэрэг зөрчлийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгч, цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсрууллаа.

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын хамгаалалтын захиргаа, “МоЭнКо” ХХК хамтран “Уул уурхайн ус ашиглалт, орчны бүсийн хамтын ажиллагааны менежмент, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, хамгаалалтын захиргаанаас сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг танилцуулж, Хөшөөтийн нүүрсний уурхай байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийлээ. Тус сургалтанд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга “Газар, газрын хэвлийн ашиглалт хамгаалалт, МоЭнКо компани анхаарах асуудлууд” сэдвээр илтгэл тавьж мэдээлэл хийлээ.

БОАЖЯ-ны 30-н жил, Монголд тахь сэргээн нутагшуулсны 25 жилийн ойн хүрээнд “Тахь эх нутагтаа” гэрэл зургийн үзэсгэлэн худалдааг Олон улсын “Тахь групп”-тэй хамтран зохион байгууллаа.

Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны даргын 2017 оны 02 дугаартай усны дүгнэлтийг үндэслэн “МоЭнКо” ХХК, “Дорнын шим” ХХК-д ус ашиглуулах зөвшөөрөл олгож, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017 оны А/34 дугаар тушаалаар ус ашиглах гэрээг байгууллаа. “Дорнын шим” ХХК-ий усны төлбөр болох 448,105 төгрөгийг Мянгад сумын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэж, зөвшөөрлийн хуулбарыг Мянгад сумын ЗДТГ-т хүргүүлэв.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд Буянт, Ховд сумдын Засаг даргын орлогч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, багийн засаг дарга, Онцгой байдлын газрын мэргэжилтэнүүдтэй хамтран Буянт голд тавигдаж буй 150 метрийн урттай 2 гүүрний ажлын явц гүйцэтгэлтэй танилцаж, голын голдирол түр өөрчилсөн асуудлаар санал солилцов.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хар-Ус нуур орчмын УТХГ нутгийн хамгаалалтын захиргаа, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Дөргөн сумын “Хөх эргийн аараг”-т гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн нөлөөлөлд өртөн эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийв. Тус газарт нөхөн сэргээлт хийх ажлын тендерт шалгарсан “Блю гоулд” ХХК нь эвдрэлд орсон талбайг тойруулан хашаалах ажлыг хийж байсан бөгөөд компаний удирдлагуудтай уулзаж “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” холбогдох заалтыг хэрэгжүүлж үйл ажиллагаандаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээлт хийх ажлын төлөвлөгөө боловсруулах, байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулах, усны дүгнэлт гаргуулж ажиллах чиглэл өглөө. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, “Байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангаж, “Тэс петролиум” ХХК, “Оюу мандал” ХХК, “Баруун Монгол Ойрд” ХХК, “Дашваанжил” ХХК, “Шунхлай” ХХК, “М-Ойл” ХХК-ын шатахуун түгээх станцууд, “Буянт стандарт” ХХК-ний өнгөт чулууны үйлдвэр, “Арслан бар” ХХК-ний өлөн гэдэс боловсруулах цехэд хяналт шалгалт хийв. Хяналтын явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдан дүгнэлт гаргуулж, мэргэжлийн байгууллагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн боловч хугацаа дууссан, тухайн жилийн байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээгүй нийтлэг зөрчлүүд илэрсэн бөгөөд хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөж, албан шаардлага хүргүүллээ.

2017 оны 11 дүгээр сарын 3-14-ний өдрүүдэд Бумбатхайрхан, Жаргалантхайрхан, Баатархайрхан уулан дахь янгирын нөөцийг тогтоох тооллогыг Монгол Улсын Их сургууль, Ховд их сургууль, Шинжлэх ухааны академийн биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сангийн биологичид, нутгийн иргэдтэй хамтран Бумбатхайрхан ууланд 84, Жаргалант хайрхан ууланд 496, Баатархайрхан ууланд 719 толгой янгир байгааг тоолж бүртгэлжүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-д заасны дагуу аймгийн хэмжээний газар нутагт ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг “Уламжлалт ав” ХХК-иар гүйцэтгүүлж, шинээр 4 сумын 6 агнуурын бүс нутаг нэмэгдсэнийг тайланд тусгаж, мэдээ тайланг аймгийн Засаг даргад хүлээлгэн өгөв. Улсын тусгай хамгаалалтанд аймгийн нийт газар нутгийн 2,654,576 га буюу 34,9 хувь, орон нутгийн тусгай хамгаалалтанд 323,106 га буюу 4,2 хувь хамрагдаж, нийт газар нутгийн 39,1 хувь нь хамгаалалтанд орсон байна.

Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа нь Мөнххайрхан уул, Баян-Өлгий аймгийн Булган сумын ирвэсийн байршил бүс нутгуудад 102 ширхэг автомат камер байрлууллаа.

“Цэвэрч Ховдчууд” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 9-11 дүгээр сард нийт 15 удаагийн цэвэрлэгээгээр 113 машин хог буюу 424м³ хур хог, Жаргалант сумын хэмжээнд 1850 иргэн, 120 аж ахуйн нэгж оролцож нийт 256м³ хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт хүргэж устгав.

2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн аймгийн ИТХ-аар 2017-2027 онд хэрэгжих “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг 5 зорилт, 27 заалттайгаар батлууллаа.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, малчин өрхийг хөгжүүлэх малчдын залгамж халааг бэлтгэх, малчин болох чин хүсэлтэй 18-37 насны мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвор суурьшилтай ажиллах шинэ залуу, залуу малчин гэр бүлийг дэмжих, тэдэнд өвөлжөө, хаваржааны газар, худгийг эзэмшүүлэх, хадлан тэжээл бэлтгэх зэрэг аж ахуйн материаллаг баазаа бэхжүүлэхэд нь туслах зорилгоор “Залуу малчин” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХ-д өргөн барьж, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

Мянгад суманд үржүүлж буй Мянгад адууг омог болгох зорилгоор явуулсан үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийх үеэр 120 адуунд үзлэг ангилалтыг хийж нэг бүрчлэн хэмжиж, жигнэн анги чанарыг тогтоох ажлыг хийж гүйцэтгэлээ. 12 дугаар сард багтаан омгоор батлуулах хянан баталгааг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөлтэй хамтран зорилтот сумдууд болох Дуут, Булган, Мөнххайрхан, Чандмань сумдын бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийж хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, ээмэгжүүлсэн малыг онлайн бүртгэлийн программд бүртгэсэн бүртгэлийн мэдээ тайлангийн хамт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт, ИТХ-ын тогтоолын биелэлт, 2018 оны үндсэн чиглэлийн төсөл, ХХААХҮСайдтай 2018 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээнд тусгах санал зэргийг холбогдох хэлтэст хүргүүллээ.

Монголын үндэсний радио телевизийн “Ургацын далай” нэвтрүүлэгийн албанд Хайрхан багийн тариаланч иргэнийг “Алтан түрүү” шагналын эзэн болгох тухай 3 жилийн хөдөлмөрийн үр дүнгийн ажил байдлын тодорхойлолт, холбогдох материалыг хүргүүлсэн бөгөөд тус шагналыг Ш.Оюунжаргал хүртэж түүний амжилтыг олон нийтэд алдаршуулав.

Аймгийн мал эмнэлэгийн албанд Буянт сумын Цагаанбургас багийн МЭҮТ-н малын эмч тугал өвдсөн дуудлага өгч, дуудлагын дагуу холбогдох малын эмч, мэргэжилтэнүүд тухайн газарт ажиллаж, шаардлагатай эмчилгээг хийж арга хэмжээ авч ажиллав.

Мянгад суманд мялзан өвчин гарч, уг өвчнөөс мал амьтнаа хамгаалж, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/573 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон 14 сумын хэмжээний 841500 толгой төл мал вакцинжуулалтанд хамруулахаар төлөвлөн ажиллаж, 680,2 мянган толгой малыг вакцинд хамруулж ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

Авто замын чиглэлээр: Зам засвар арчлалтын “Ховд АЗЗА” ТӨХК нь зам засварын ажлаас гадна Ховд-Говь-Алтай чиглэлийн 269 км авто зам дагуу Манханы

гурван замын уулзвар хүртэлх авто зогсоолуудад хогийн цэг, бие засах газар /эр, эм/ 5 цэгт шинээр байрлуулав.

Үүнээс гадна хариуцсан бүх чиглэлийн авто замуудын тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг хангаж, цагдаагийн байгууллагатай хамтран ард иргэд, зорчигчдод замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар, зөрчлийн хуулийг суртачлан ажиллав.

Зээлийн батлан даалтын сан, Азийн хөгжлийн банктай хамтран батлан даалттай зээлийн төслийг 10 хүртэлх жилийн хугацаатай Төрийн болон Хас банкаар дамжуулан 12-15 хувийн хүүтэйгээр олгохоор төлөвлөн ажиллаж байна.

2017 оны 11 дүгээр сарын 07,08-ны өдрүүдэд манай аймагт Худалдаа аж үйлдвэрийн танхимын баруун бүсийн хурал зөвлөгөөн болж, тус хуралдаанд БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн төлөөлөгчид болон баруун таван аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл, бизнес эрхлэгчид нийт 50 гаруй хүн оролцлоо. Жилийн хурлаар 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл болон цаашид хийхээр төлөвлөсөн ажил, 2018 онд хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцон хамтын ажиллагааны санал зөвлөмжид 2 орны төлөөлөл гарын үсэг зурж баталгаажуулав.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэх, ахуйн үйлчилгээний ажиллагсдын мэргэжил ур чадвар, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Ахуйн үйлчилгээний өдөрлөг”-ийг 2017 оны 11 дүгээр сарын 17-20 -ны өдрүүдэд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын А/553 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дэмжлэгтэйгээр мэргэжлийн холбоод “Ахуйн үйлчилгээний салбар”-ын ажиллагсдад сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцлоо.

Мөн үсчин болон оёдолчдын мэргэжлийн ур чадварын тэмцээн, гутал үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, гар бөмбөгийн тэмцээн зэргийг зохион байгуулж, шагналт байрын эздэд өргөмжлөл, Жаргалант сумын сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын ХЭДСангийн дэмжлэгт хамрагдах эрхийн бичгээр шагнаж урамшуулав.

Сум хөгжүүлэх сангаас олгогдсон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт удааширч аймгийн хэмжээнд 1.0 тэр бум гаруй төгрөгийн өрийн үлдэгдэл байгаа бөгөөд өр барагдуулах ажлын хэсэг томилогдон сумдын Засаг дарга нарт хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэн ажилласны үр дүнд 56 төслийн 142,2 сая төгрөг төлөгдсөн.

Аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын алба нь 62 хүнсний дэлгүүр, 1 зоогийн газар, 2 караоке, 1 пиццаны газар болон Мөнх-хайрхан, Булган, Алтай, Үенч сумдын 53 аж ахуй нэгж нийтдээ 119 аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтанд хамруулан тохирлын гэрчилгээ олгож ажиллав.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг 2017 оны 9 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 26-ны өдрүүдэд сум, байгууллагуудын үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, бодлогын баримт бичиг, хөтөлбөр,

эрх зүйн актуудын хэрэгжилт, үр дүн, орон нутаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтын явцтай танилцан заавар зөвлөгөө өгч, зөвлөн тусалж ажиллав. Сум, байгууллагуудад ажилласан талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 17 сумдын Засаг даргын Тамгын газар болон 64 төсөвт албан байгууллага, 79 баг, 28 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мөрөөр 15 үзүүлэлтийн дагуу зөвлөмж боловсруулж, Жаргалант сумын 15 цэцэрлэг, 7 сургууль, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 12 баг, 28 байгууллага, 17 суманд зөвлөмж хүргүүлээд байна.

Аймгийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аймгийн ИТХ-ын 76 тогтоол шийдвэрийн 128 заалтын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2017 оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар нэгтгэн гаргаж, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу, заалт тус бүрийн хэрэгжилтийн явцын байдалд тодорхой үнэлгээ өгч тооцож гаргахад тогтоол шийдвэрийн хэрэгжилт 81.2 хувийн хэрэгжилттэй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаар нэг бүрчлэн танилцуулбал:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 67 тогтоолын 104 заалтын дундаж хувь 81.6;

2. Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааны 2 тогтоолын 8 заалтын дундаж хувь 85.0;

3. Аймгийн ИТХ-ын 7 тогтоолын 16 заалтын дундаж хувь 76.9 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Дээрх үнэлгээнээс харахад тогтоол шийдвэрийн хэрэгжилт 81.2 хувьтай байгаа нь төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагч, удирдах ажилтнууд ач холбогдол өгч, шуурхай зохион байгуулж, явцын болон үр дүнгийн хяналт тогтмолжсон нь харагдаж байна.

Мөн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоолын биелэлтийг хяналтаас хасах саналын тогтоолын жагсаалт, зурган тайлан болон аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлийн хамт 2017 оны 2/2666 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийн жагсаалтын дагуу www.legalinfo.mn сайтаас татаж аймагт хэрэгжүүлэх УИХ-ын тогтоолоор батлагдсан 7, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 32, нийт 39 үндэсний хөтөлбөрийн жагсаалт гаргаж, 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 2/2770, 2771, 2772 тоот албан бичгүүдээр, мөн төрийн мэдээллийн сүлжээний www.unelgee.gov.mn сайтаас Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын тогтоол шийдвэрийг татаж, хэлтэс, сум, байгууллагуудад тус тус хүргүүлэв.

Тайлант сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 45 тогтоол, 15 хуралдааны тэмдэглэл, албан даалгавар 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 112 тогтоол хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, төсөв хөрөнгө зарцуулах тухай, болон аймаг сумын Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн явцын тухай мэдээлэл зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд сумын өвс тэжээлийн нөөцийн сангаас 1,7 сая төгрөг, ЗДТГ-ын нэмэлт данс буюу сумын 90 жилийн ойн хандивын данснаас 1,5 сая төгрөг гаргаж, 10 тн өвс худалдан авч сумын нөөц бүрдүүлээ.

Сумын ЗДТГ-аас малчдын 2 дахь удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудал, өвөлжилтийн бэлтгэл хангасан байдал болон бэлчээрийн асуудлыг хөндсөн өргөн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Зөвлөгөөний хүрээнд аймгийн ЗДТГ-аас санаачлан хэрэгжүүлж байгаа “Малчиддаа тусалъя” 3 сарын сайн санааны аяны нээлтийг хийж, аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцууллаа.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж, сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан сумын хэмжээний бог малын төлд гоц халдварт мялзан өвчний эсрэг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж байна. Ажлын хэсэгт хувийн Мал эмнэлэгүүд, Багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нар, мөн сумын цэргийн дүйцүүлэх албаны албан хаагчдыг татан оролцуулсан ба ажлын явц гүйцэтгэл 40%-тай байна.

Аймгийн хэмжээнд зуншлага тааруу өвөлжилт хүндрэлтэй байгаа шалтгаанаар зарим сумдаас тус сумын нутагт оторлон ирэх малын тоо толгой зохистой тоо хэмжээнээс хэтэрсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг 4 багт ажиллууллаа. Дээрх ажлын хэсэг багийн нутаг дэвсгэрт сум хоорондын гэрээгүйгээр орж ирсэн болон гэрээнд заасан хугацаанаас өмнө орж ирсэн өөр сумын малчид, малыг хөлсөөр хүлээн авсан тус сумын малчидтай хариуцлага тооцож, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллаж байна. Цаашид тус сумын нутаг дэвсгэрт отроор болон тавиулаар ирэх малын тоо толгой нэмэгдсээр байх төлөвтэй байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2017 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Цэргийн дүйцүүлэх албаны 2 өдрийн сургалтыг Мөст суманд зохион байгуулж, дээрх арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг бүрэн оролцууллаа.

Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын багцаас Хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоомын талбай барих 10,0 сая төгрөгийн өртөгтэй төслийг уламжилж, шийдвэрлүүлэн 3ш тоглоом, талбайн хашилт хамгаалалтын ажлыг гүйцэтгүүлэхээр ажлын гэрээ байгуулан төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Ойн хандивын мөнгөнөөс тодорхой бүтээлч ажилд зарцуулах талаар Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн Иргэний танхимын тохижилтонд 2,5 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэж, нийлүүлэх хөрөнгийн жагсаалт гарган, нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийж эхлээд байна.

Сэнхэр багийн төвийн дээд лагерын худагны насос шинээр авч, засвар үйлчилгээг хийснээр ойролцоох өрхүүдийн цэвэр усны хэрэгцээг хангаад байна.

Сумын орон нутгийн төсөвт байгууллагууд болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн, 3 дугаар улирлын тайлан болон шилэн дансны мэдээллийг хугацаанд нь шивж, нэгдсэн системд илгээв.

Орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 21648.9 мян/төг, орон нутгаас төсөвт төвлөрөх орлогоор 670.3 мян/төг төвлөрч, үүнээс ИТХ-д 3352.2 мян/төг, ЗДТГ-т 19254.7 мян/төг-ийг тус тус санхүүжилтэнд олгов. Орон нутгийн хөгжлийн санд жилийн дүнгээр 51809.1 мян/төг батлагдаж, МЭУСАХ-ний санхүүжилтэнд 16100.0 мян/төг-ийг мал эмнэлэгүүдэд хувиарлан олголоо. Худалдан авах ажиллагааны тайлан гаргаж Орон нутгийн өмчийн газарт цаас болон цахимаар хүргүүллээ. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээнүүд батлагдсан төсвийн дагуу тендер шалгаруулалт, шууд худалдан авалт хэлбэрээр хуулийн дагуу хэрэгжиж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээр нийт 81392.6 мян/төг ирснийг 12 жилийн сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад санхүүжилт олгож зарлагын гүйлгээнүүд хийгдэв.

Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс хамтран зохион байгуулсан “Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт хэрэгжилтийг сайжруулах” сэдэвт сургалтанд санхүүгийн албаны дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, төсөвт байгууллагын нягтлангууд оролцож хууль эрх зүйн актуудын өөрчлөлтийн хэрэгжилт, одоогийн санхүү бүртгэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсож, сургалтанд хамрагдав.

Тус сумын Эрүүл мэндийн төвд тайлант сард 17 хүн хэвтэн хэвтэн эмчлүүлж, эмийн бус эмчилгээгээр 58 хүнд үйлчлэв. 0-2 насны 28 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд бүрэн хамруулж, улаан бурхан, улаануудын вакцинаар 15 настай 40 хүүхдийг дархлаажуулав. “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний В,С вирусын шинжилгээнд тайлант сард 27 хүнийг хамруулсан ба сумын хэмжээнд нийт 282 хүн хамрагдаж хамрагдалт 60 хувьтай байна.

Сумын ард иргэдийг урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмч нарын дотор-зүрх судас, мэдрэл, эхо үзлэг, 40, 45, 50, 55, 60, 65 насны иргэдийн эрүүл мэндийн багц шинжилгээнд бүрэн хамруулж, давхардсан тоогоор 291 иргэн үзлэгт, 50 иргэн багц шинжилгээнд хамрагдав.

Урлаг соёлын болон танин мэдэхүйн 6 үйл ажиллагаа зохион байгуулагдаж, 472 үйлчлүүлэгч хамрагдаж, 363.600 төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Сумын ЗДТГ-аас мал аж ахуйн өвөлжилтийн байдал, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл өгөх зорилгоор малчдын зөвлөгөөн хийж, хэлэлцүүлэг зохион байгуулж, 4 багийн малчдыг төлөөлсөн 60 гаруй малчин оролцлоо. Зөвлөгөөнөөс мал өвөлжилт, хаваржилттай холбоотой зөвлөмж гарган нийт малчин өрхүүдэд хүргэж, сурталчлах, зөвлөгөөний зөвлөмжийн мөрөөр өөр аймаг сумаас өвөлжиж буй малын толгой /бог/ тутамд газар ашиглалтын төлбөр оногдуулах, БИНХ-ын шийдвэр зөрчиж гэрээ хэлэлцээргүй болон гэрээний хугацаанаас өмнө мал оруулсан иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, малын эрсдэлийн сан бүрдүүлэх, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг 12 сарын 01-с өмнө зохион байгуулах, Малын эрүүл мэндэд онцгой анхаарах, төл малд хийгдэх бог малын

мялзан төст өвчний вакциныг богино хугацаанд хийж дуусгах, бог малын хээлтүүлэгчийг ялган суурилах зэрэг ажлуудыг 11 дүгээр сард багтаан хийж гүйцэтгэлээ. Сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 4 багт ажилласан 7 хоногийн хугацаанд 30 гаруй өрхийн 29,0 мал Баян-Өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Чандмань, Манхан, Зэрэг сумаас малчид ирж өвөлжиж буй мэдээ судалгаа гаргасан ч тоо нэмэгдсээр байна. Малчин, мал бүхий иргэдээс үндэсний үйлдвэрт тушаасан хонь, тэмээний ноос, бэлтгэсэн арьс ширний талаарх саналыг 40 гаруй иргэнээс авч холбогдох газарт хүргүүлэв.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас сумдын эко клубын сурагчдын үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд тус суманд 5 автомат камер суурилуулах ажлаар ДБХСан, Мөнххайрхан сумын Байгаль хамгаалагч, Алаг багийн “Ахууна” байгаль хамгаалах нөхөрлөлийн идэвхитэн байгаль хамгаалагч, сумын Цагдаагийн хэсгийн байцаагч, “Цаст гялбаа” эко клубын багш, гишүүдийн хамтарсан баг Хаг багийн Тасын нуруунд, Алаг багийн Шагайн оройд, Алагийн Хөндийд, Алаг багийн Модны эхний Өндөр харын оньд нийт 5 камер суурилуулсан.

Сумын Засаг даргын 2017 оны А/123 дугаар захирамжаар Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, ажлын хэсгийн хурлыг 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хийж, “Агаар бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг танилцуулж, хөдөлгөөнт болон суурин эх үүсвэрийн тооллогыг ажлын хэсгийн гишүүдэд жигд хувиарилж, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргэхээр шийдвэрлэв.

“Цэвэрч Ховдчууд” болзолт уралдааны хүрээнд ажлын удирдамж батлуулан төлөвлөгөө гаргаж, удирдамжийн дагуу ЕБС-ийн 3-12 дугаар ангийн сурагчдын дунд байгаль орчны чиглэлийн танин мэдэхүйн болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх улалдаан тэмцээнийг гар зураг, шүлэг, эссэ бичлэгийн төрлөөр, 3-5 дугаар ангийн сурагчдын дунд “Хоггүй Мөнххайрхан” сэдэвт гар зургийн уралдаан, 6-8 дугаар ангийн сурагчдын дунд “Мөнххайрхан суманд байдаг ховор амьтан, ургамлын талаар” шүлгийн уралдаан, 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Би Байгаль хамгаалагч” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан тус тус зохион байгуулж байр эзэлсэн хүүхдүүдийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хууль дүрэм бодит амьдралд” аяны хүрээнд “Тайван амгалан орчин бүрдүүлэхэд иргэн миний оролцоо” сэдэвт 9 сарын аян өрнүүлж, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн ажилтан хамтран аянд хэрхэн нэгдэх, хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл өгч, ажилтнуудын заавал судлах хуулийг сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусган, төлөвлөгөөний дагуу 26 ажлыг хэрэгжүүлж, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын хуулиудыг сурталчлан сургалт сурталчилгааг өргөн цар хүрээтэй, үр дүнтэй зохион байгууллаа

Мөн дэлхийн байгаль хамгаалах сан, Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Байгаль хамгаалах малчдын бүлэг, нөхөрлөлүүдийн дунд “Байгаль хамгаалах нөхөрлөлийн өдөр” зохион байгуулж, Баян-Өлгий аймгийн 2, Мөнххайрхан сумын 5, нийт 7 нөхөрлөлийг хамруулан, Цагаан идээ, гар урлалын үзэсгэлэн худалдаа, байгаль хамгаалах үйлсэд нэгдсэн иргэдийн дунд хэлэлцүүлэг хийж, шилдэг нөхөрлөл шалгаруулж, урлаг соёлын болон хүндэтгэлийн арга хэмжээ зэрэг үйл ажиллагааг дэмжиж ажиллав.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн хяналт шалгалтын ажлын хэсэг сумын ЗДТГ болон төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, 81,3 хувь буюу 1,6 оноо сайн үнэлэлт өгч, зарим нэг ажил сайжруулах, анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөв. Мөн Боловсрол, соёл урлагийн газрын ажлын хэсгийн баг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж БСШУСЯ-ны баримтлах бодлогыг сурталчлах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах чиглэл өгч, сургуулийн дотуур байр, үдийн цай нийлүүлэлтийн явцтай танилцаж зөвлөн туслав.

Сумын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүнс худалдаалдаг, үйлчилгээ явуулдаг газруудад хяналт шалгалт хийж, байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт, татвар ногдуулалт, татварын эх үүсвэрийг бодитой тогтоох зэрэг хяналт хийв.

Булган сум: Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Байтаг багийн Шуудай, Алагтолгой багийн Яам, Баянгол багийн Тошилтод гүүр барих ажлыг эхлүүлж, 21 метрийн урттай, 1,20 өргөнтэй Шуудайн гүүр, Яамны гүүрийг сумын ЗДТГ-ын нийт ажилтнууд, багийн иргэдийн хамтын хүч, хөдөлмөрөөр барьж ашиглалтанд оруулав. Аймгийн Засаг даргын 2017 оны А/548 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/115 дугаар захирамжаар “Малчиддаа тусалъя” сайн санааны аян өрнүүлэх ажлын хэсгийг байгуулан, ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу тус аяны талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээж, хандив цуглуулах ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Нэрт зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 111 жилийн ойг тохиолдуулан номын сангаас 10 хоногийн өдөрлөг зохион байгуулахаар төлөвлөн, 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Нацагдоржийн шүлгийг хэн сайн унших вэ” шүлгийн уралдаан, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд Богино өгүүллэгийн тэмцээн, 10-12 дугаар ангийн сурагчдын дунд Номын ертөнцөөр аялахуй ЭССЭ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж, амжилттай оролцсон шилдэгүүдэд шагнал гардуулж ба хүргэв.

Засаг даргын 2017 оны А/14 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж амьдарч буй харъяалалгүй 24 өрхийн 142 иргэнийг бүртгэлжүүллээ.

Байтаг багийн 2.8 га газарт хээрийн түймэр, Алагтолгой багийн 840 сот газарт хээрийн түймэр гарч, аймгийн Онцгой байдлын газар, сумын Засаг даргын Тамгын

газрын албан хаагчид болон багийн иргэдийн хамтын хүчээр бүрэн унтраав. Түймэрийн голомтод Онцгой байдлын галын 2 машин, 150 нутгийн иргэд ажиллав.

Бог малын мялзан төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээний нийт 32339 төл малд хийж дархлаажуулав.

Алтай сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 11 дүгээр сарын 22-ны өдөр хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд: Төсөвт албан байгуулагуудын ашиглалт элэгдлийн хугацаа дууссан 82 нэр төрлийн 14628,2 мянган төгрөгийн өмчийг актлах, ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдааныг 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэж, сумын ЗДТГ-ын мэргэжилтэнүүдийн 2017 оны ажлын гүйцэтгэл тайлангийн мэдээлэл сонсож үнэлэлт дүгнэлт өглөө.

Хилийн цэргийн 0130-р анги Хил хамгаалах туслах хүчний уулзалт болж, тус уулзалтанд сумын удирдлагууд оролцож ажил үүргээ амжилттай гүйцэтгэсэн алба хаагчдыг шагнаж урамшуулав.

Аймгийн Прокурорын газар, Стандарт, хэмжилзүйн хэлтэс хамтран “Өдөр бүр манлайллыг дэмжье” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтанд баруун 3 сумдын бизнес эрхлэгчид оролцон “Чанарыг эрхэмлэгч” бизнесменийг тодруулж уг шагналын эзэнээр Алтай сумын бизнес эрхлэгч С.Отгонбаяр шагнагдав.

Сумын Цэцэрлэгийн хамт олон Цэвэрч Ховдчууд аяны хүрээнд “Бидний оролцоо” сэдэвт байгалийн булан ажиллуулж, анги бүлгүүд сэдвийнхээ дагуу үзүүлэн, гаргаж, тус үзүүлэнг сургалтандаа ашиглан дасгал ажил хийж сургалтын төвүүдээ баяжуулан байгууллагын хэмжээгээр нийт 59ш сав цэцэг шинээр тарьж эко орчин бүрдүүлэн ажиллаа.

Сумын ЗДТГ-ын хамт олноос санаачлан “Өглөгийн хур, өөрчлөгдсөн амьдрал” сайн үйлсийн гурван 7 хоногийн аян өрнүүлж, тус аянд сумын төсөвт албан байгууллагууд болон төрийн бус байгууллагын төлөөлөл аж ахуйн нэгж, хувийн хэвшил, ард иргэдийг нээлттэй оролцуулж Алтангадас, Тахилт багийн зорилтот бүлгийн 6 өрхөд 570000 мянган төгрөгийн хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн өрх тус бүрт 2 тн нүүрс, хар мод 2 ширхэгийг сумын удирдлагууд аянд нэгдсэн төлөөллийн хамт гардуулж өглөө.

Дөргөн сум: Аймгийн ЗДТГ-аас санаачлан өрнүүлсэн Малчиддаа туслах аяныг дэмжиж, сумын ард иргэдэд тус аяны зорилго үйл ажиллагааг танилцуулж, сумын Засаг даргын А/87 дугаар захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мялзан өвчнөөс мал амьтнаа хамгаалж, урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/96 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон сумын хэмжээний 53600 толгой төл мал вакцинжуулалтанд хамруулж, гүйцэтгэл 40%-тай байна. Мөн мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдтэй хамтран хөдөөгийн 3 багийн 42000 төл 42000 төл, 85,8 мянган ямаа, 28,5 мянган хонинд эрүүл мэндийн үзлэг тандалт хийв.

Тайлант оны татварын өртэй 5 татвар төлөгчийн 132000,9 өмнөх оны татварын өртэй 1 аж ахуй нэгжийн 9350000 төгрөгийн өрийг бүрэн барагдуулж, Аж ахуйн нэгжийн НӨАТ-н тайланг хуулийн хугацаанд аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

Нийгмийн даатгалын 349 тэтгэвэр авагчдад 274951,0 төгрөгийн санхүүжилтээр өндөр насны тэтгэвэр авагч 247, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 34, тахир дутуугийн тэтгэвэр авагч 68 иргэнд олгож, сайн дурын даатгалд 58 даатгуулагчийн 2755425,000 төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн даатгалд 22 хүний 846720,000 төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэв.

“Цэвэр Ховдчууд” болзолт уралдаан зарлах тухай аймгийн Засаг даргын А/391 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, сумын Засаг даргын А/83 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан аяны төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу 7 хоногийн 5 дахь өдрийг бүх нийтийн цэвэрлэгээний өдөр болгон албан байгууллага, айл өрх тус арга хэмжээнд идэвхтэй оролцож сумын хэмжээнд 20 машин хогийг хогийн устгав.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар 24 өрхийг сонгон зорилтот өрхөөр сонгож, холбогдох хууль тогтоомжийн дагуу 6 өрхийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамруулж 4225000 төгрөгийн хүнсний бараа олгов. Мөн малжуулах хөтөлбөрт Аргалант, Сээр багийн 2 малчин өрхийг, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд асран хамгаалагчийн тэтгэмж тогтоолгон, зорилтот өрхийн хөдөлмөрийн насны 3 гишүүдийг нийгмийн даатгалд хамруулж, Зорилтот 1 өрхөд гэрээр оёдлын үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгож хөдөлмөр эрхлэлтийн сангаас 1500000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлэв. Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 18 иргэнийг хамруулж, 15,1 сая төгрөгийг олгов.

Шинээр газар эзэмших 1, өмчлөлөө салгуулахыг хүссэн 1, өвөлжөө хаваржаа хүссэн 1, гэр бүлийн зориулалтаар газар олгохыг хүссэн 1 өргөдөлийг хүлээн авч, нэгж талбарын хувийн хэрэг хөтлөн эзэмшлийн гэрчилгээг 2 иргэнд олгож, эзэмшлийн газрыг эздэд нь хүлээлгэн өгөв. Газар өмчлөн эзэмшиж ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгуулагуудаас газрын төлбөр татварт 3939000 төгрөг ногдуулав. Сумын 40-65 насны 38 иргэдийг архаг өвчлөл, үе мөчний эмгэг, хавдрын эрт илрүүлэгийн 3 багц шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулав.

Аймгийн Залуу багш нарын нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Алтан өв-Чадварлаг багш” урлагийн анхдугаар наадамд 10 багш оролцож, сургалтын үйл ажиллагааг хэрхэн яаж сайжруулах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд юунд анхаарч ажиллах талаар бусад багш нартайгаа туршлагаа хуваалцлаа.

Сумын ЕБСургууль 2017-2018 оны хичээлийн жилд нийтдээ 6 кабинетыг тохижуулж, гэрчилгээ олгосон ба тус хичээлийн жилд 3 багш тэргүүлэх зэрэг, 1 багш заах аргач багш мэргэжлийн зэрэг авч, дотуур байрны сурагчдын аюулгүй байдлыг хангах, хараа хяналтыг сайжруулах зорилгоор 4ш камер суурилуулав.

“Малчиддаа тусалъя” аянд нэгдэж сургуулийн багш, ажилчид 33 нэмнээ, 23 хошуувч, 35 бээлий, цаг агаарын мэдээ хүлээн авах зааврын гарын авлага 120ш хэвлэж малчдад хүргүүлэхээр сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгөв.

Сумын Соёлын төв Номын сангийн дэргэдэх уран уншлага драмын дугуйлан хичээллүүлэх удирдамж боловсруулан батлуулж, суралцагчдын бүртгэлийг эхлүүлээд байна. Мөн Хөдөлгөөнт өвийн бүртгэлд 4ш үзмэр бүртгэж, Дөрвөд түмний дуун цацал, Наараан суутан, Дөрвөн бэрх, Адуучин тэмцээний дүрс бичлэгийг цахим мэдээллийн санд бүртгэн баримтжууллаа.

Зэрэг сум: Монгол улсын Зэвсэгт хүчний жанжин штабаас бригадын хурандаа Б.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж, Локаторын цэргийн анги байгуулах асуудлаар сумын удирдлагуудтай харилцан ярилцаж, санал бодлоо солилцов.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах Засгийн газрын 186 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 01, аймгийн Засаг даргын 05, 07 албан даалгаврын хэрэгжилтийг хангаж сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан 3 бүлэг 27 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Мал эмнэлгийн 5-н нэгжийн үйл ажиллагаанд сумын ЗДТГ-ын баг хяналт хийж, 2017 оны ажлын тайлан болон мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын мэдээг сонсож төл малын вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэл өгөв.

Буянт сум: Тайлант сард иргэдээс бичгээр 98 өргөдөл хүлээн хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэв. Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 322 иргэнд үзүүллээ. Үүнд: шинээр төрсөн 71 хүүхэдэд, гэрлэлтийн бүртгэл 27 иргэнд, нас баралт 19, иргэний шинэчилсэн бүртгэл 140 иргэнд үзүүлж, үүнээс анх удаа иргэний үнэмлэх авч байгаа 16 настай 59, 25 насны сунгалт 47, 45 насны сунгалт 34, эцэг тогтоолтын бүртгэл 10, эд хөрөнгийн анхны бүртгэлээр 65 иргэнийг тус тус хүлээн авч тус тус үйлчиллээ.

Тайлант сард орон нутгийн төсвийн орлого 47,6 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 42,7 сая төгрөг төвлөрүүлж, 89.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 195246,8 мянган төгрөгийн дэмжлэг авч, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагууд төлөвлөгөөний дагуу байгууллагын 983990,3 мянган төгрөгийн санхүүжилтийг 100% авсан. Сум хөгжүүлэх сангийн дансанд үндсэн зээл, хүүгийн төлбөрт 53,5 сая төгрөг төвлөрүүллээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зарлага санхүүжилтийн 11 дүгээр сарын мэдээг ЗДТГ-ын ил тод байдлын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлсэн ба 5 төрлийн тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь чанартай нэгтгэн гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүллээ.

Наранхайрхан багийн нутаг дэвсгэр хүрэн дэлтэд худаг, мал угаах суурин ванныг 13,0 сая төгрөгөөр, Норжинхайрхан багт 14,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр худаг гаргаж, уст цэгийн тоог нэмэгдүүлэв.

Сумын эрүүл мэндийн төв нь нийт 412 хүнд үзлэг хийсэн ба үүнээс урьдчилсан сэргийлэх үзлэг 174 иргэнд, өвчний учир амбулаториор 161, гэрийн идэвхитэй эргэлт 20, идэвхитэй хяналтаар 34 удаа явж үйлчилсэн. Нийт 19 өвчтөн хэвтэн эмчлүүлж, алсын дуудлагад 23 удаа явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай хүргэж үйлчлэв. Жирэмсний хяналтанд шинээр 2 эхийг хяналтанд авч, 35, 40, 45, 50, 55, 60, 65 настай иргэдийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, зохих шинжилгээнд үнэ төлбөргүй хамрууллаа. Бог малыг мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын хэмжээний бог малыг эрүүл мэндийн үзлэг болон вакцинжуулалтанд бүрэн хамруулах, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын А/107 дугаар захирамжаар байгуулж, тус ажлын хэсэг 5 багийн 49287 төл малыг вакцинжуулж ажиллав.

Манхан сум: Сумын ЗДТГ-аас орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны явцыг сайжруулах ажлын төлөвлөгөө гарган байгууллагуудад хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Ахмадын хорооны даргаар ахлуулсан ажлын хэсэг сумын ахмадуудтай уулзаж, 2017 онд хийж гүйцэтгэсэн ажил, 2018 онд хийхээр төлөвлөсөн ажил, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт, Ахмадын сангийн зарцуулалтын талаар тайлан тавьж мэдээлэл хийлээ.

Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлт, “Хууль журам-Миний амьдралд” аяны хүрээнд хийгдсэн ажлын тайлан, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт, хэрэгжилтийн явцыг тооцон холбогдох газруудад хүргүүлэв.

“Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд Залуу багш нарын холбооноос зохион байгуулсан “Алтан өв-Чадварлаг залуу багш” урлагийн анхдугаар наадамд сумын ЕБС-ийн залуу багш нарын баг оролцож нийт 26 багаас III байранд шалгарсан амжилттай оролцов.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард 48 иргэнийг хэвтүүлэн эмчилж, урьдчилан сэргийлэх үзлэгээр 311 иргэнийг хүлээн авч эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж үйлчлэв. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 32 хүүхэд хамрагдаж, 2 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 9 дуудлаганд үйлчилээд байна.

0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж 90 хувийг тендэрээс авч хэрэглэж байна.

Мөст сум: Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилтийн биелэлтийг тооцож холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр УБ хотод эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай 5 иргэнд унааны нэг талын зардал 295000 төгрөгийн хөнгөлөлтийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн хуулийн дагуу шийдвэрлүүлэв. Ахмад настны шүдний хөнгөлөлтөнд 2 ахмадыг хамруулж, 240000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлэв. Мөн асаргаанд орох хүсэлтэй 2 иргэний өргөдөлийг хүлээн авч амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн.

“Цэвэрч ховдчууд аяны хүрээнд” иргэдийн нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, босоо тэнхлэгийн авто замаас сумын төв хүртэлх 20,3 км замын дагуух хог хаягдлыг түүж цэвэрлэв. Тус арга хэмжээнд сумын ЗДТГ, албан байгууллагуудын ажилтнууд оролцож 20 тэвш хог устгав.

Сумын Эрүүл мэндийн төв 318 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, гэрийн идэвхтэй хяналтанд 119 иргэн, жирэмсний хяналтанд 2 эхийг шинээр авч, гэрийн

идэвхтэй эргэлтээр 77, дуудлагаар 32 хүнд үйлчилж, хэвтэн эмчлүүлсэн 31 иргэнд эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай хүргэж ажиллаа.

Чандмань сум: Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 7, гэрлэлт 3, нас баралт 4, шилжин явсан 5, шилжин ирсэн 10, 25, 45 насны иргэдийн паспортын сунгалт хийж, 13 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Сумын эрүүл мэндийн төв нь 381 иргэнд амбулаториор үйлчилж, товлолын дархлаажуулалтын 10 хоногоор хоёртын вакциныг 8 настай 42, 15 настай 18 хүүхдийг, томуугийн эсрэг вакциныг өндөр настан 65 ахмадад, 20 жирэмсэн эхийг тус тус хамруулаад байна.

Сумын Номын сан 871100 төгрөгөөр 52 ш ном худалдан авч сан, номын сангийн фондод баяжилт хийлээ.

Жаргалант сум: Сумын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сарын аяныг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулан постууд болон түүхий эд худалдан борлуулдаг зах, худалдааны төвүүдээр байнгын хяналтыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Хувийн хэвшлийн цэцэрлэг болон хүүхэд харах үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хяналт хийж, хүүхэд харах үйлчилгээний эрх авсан төвийн ажилтнуудад “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, Хөдөлмөрийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудаар сургалт зохион байгуулж, тэдний санал хүсэлтийг нь сонсов. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах “Нэгдүгээрт хүүхэд” аяны хүрээнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран оройн 20.00 цагаас 24.00 цаг хүртэл РС, тоглоомын газар, биеийн тамирын заал, баар цэнгээний газруудаар хяналт шалгалт хийж зөрчил илэрсэн газруудын хяналтыг сайжруулах талаар Цагдаагийн газарт албан тоот хүргүүлэв. Ховд хотын төвлөрсөн хогийн цэгийн тархалтыг бууруулах зорилгоор сумын санхүүжилт болох 25 сая төгрөгийн хөрөнгөөр хамгааллын хашаа бариулахаар “Панцас” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР